

## Зохион зааварлах хэлтэс

1924-3-7-нд Засгийн газрын 4-р хурлаар Нийслэл хүрээнд хотын захиргаа байгуулах, түүний түр зуурын дүрмийг баталжээ.

1924-8-11-нд Нийслэл хүрээнд хотын захиргаа байгуулжээ.

Хотын түр захиргаа байгуулсаны дараа “Нийслэлийн түр захиргааны хэрэг эрхлэх газрын захиргаа” гэсэн үгтэй, хотын захиргааны тамга, мөн хороодын тэмдгийг баталжээ.

1924-11-26-нд улсын анхдугаар Их хурлын 14-р тогтоолоор нийслэл хотын нэрийг Улаанбаатар хот гэж нэрлэхээр тогтоосон.

1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

1926 оны 9 дүгээр сарын 3-нд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хотын захиргааг Дотоод яамны харъяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг татан буулгасанд тооцох, Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч,

нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1931 оны 9 дугаар сарын 21-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-нд хийхээр тогтоожээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-нд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хуралаар батлагдахаар заажээ.

1937 оны 02 дугаар сарын 13-нд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн “Улаанбаатар хотыг захирах яам” болгосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг /

- - Захирах тушаах хэлтэс

1937-5-4-нд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

- - Захирах тушаах хэлтэс

1932 оны 8 дугаар сарын 22-нд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

**1938 оны 04 дүгээр сарын 1- нд СнЗ-ийн хуралаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.**

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1940-10-3-нд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

1952 оны 11 сарын 01-ээс Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа - хэмээх болсон.

1956-2-11-нд Сайд нарын Зөвлөлийн 20 дугаар шийдвэрээ раймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд **зохион зааварлах хэлтэс** байгуулж хэлтсийн даргын үүргийг хариуцлагатай нарийн бичгийн даргад хариуцуулжээ.

1957-7-6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 104-р зарлигаар үндсэн хуулийн зарим зүйлд өөрчлөлт оруулж аймгийн ба Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд дор дурдсан хэлтсүүд байхаар тогтоожээ. Үүнд:- Зохион зааварлах хэлтэс

1958-5-7-нд сайд нарын Зөвлөлийн 124-р тогтоолоор аймаг, хотын **зохион зааварлах** хэлтэст боловсон хүчний тасаг байгуулж түүнд аймгийн захиргааны ажилтан ажилчид , төвийн улс, аж ахуйн байгууллагын дарга, орлогчид сум, хороодын дарга, орлогч нарийн бичгийн дарга, тоо бүртгэгч нарт холбогдсон боловсон хүчний асуудлыг эрхлүүлжээ.

1961-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс, **хөдөлмөрийн товчоо, тээврийн хэлтсийг** татан буулгаж мөн захиргааны

- - Зохион зааварлах хэлтэс
- Ерөнхий хэлтэс гэж баталсан.

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

- БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.

1965 оны 06 дугаар сарын 01-нд Сайд нарын Зөвлөлийн 601 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг

- - Зохион зааварлах хэлтэс
- орон тоог 60 нэгчээр баталжээ.
- 1965-6-11-нд Сайд нарын Зөвлөлийн 190-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг
- - Зохион зааварлах хэлтэс

1968-6-7-нд Сайд нарын Зөвлөлийн 185 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг

- - Зохион зааварлах хэлтэс

1975-2-27-нд Сайднарын Зөвлөлийн 104-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг дор дурдсанаар баталжээ.

- а/ Зохион зааварлах хэлтэс

1978-9-11-нд Сайд нарын зөвлөлийн 294-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орон тоог 102 нэгжээр, зохион байгуулалтыг

а/ Зохион зааварлах хэлтэс

1989 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 152 дугаар тогтооор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дарга 1, нэгдүгээр орлогч 1, Орлогч дарга 1, /Нийгэм соёл эрхэлсэн, барилгын асуудал эрхэлсэн, орон сууц, нийтийн аж ахуй, хот тохижуулах эрхэлсэн/ хариуцлагатай нарийн бичиг 1 тус тус батлаад аппаратын бүтэцийг нь

#### **Зохион зааварлах хэлтэс**

1989 оноос өмнө аймаг, хотын хурал, гүйцэтгэх засаглал/ хоёр/ нь нэг даргатай байсан ба 1989 оноос хойш Монгол Улсын аймаг, хотын хурал биеэ даан /орон тооны бус/ даргатай, тэргүүлэгчидтэй болжээ. 1989-1990 Улаанбаатар хотын Ардын Депутатуудын хурлын Тэргүүлэгчдийн хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байсан. 1990 оны 01 дүгээр сараас УБХ-ын Ардын хурал гэх болсон. 1990 оны 07 дугаар сар хүртэл ажиллаж байсан тэр үед хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байв.

Сайд нарын зөвлөлийн 1990 оны 06 дугаар сарын 08-ны 297 дугаар тогтоолоор УБХ-ын АДХГЗ-ны Удирдлагын орон тоог дарга 1, нэгдүгээр орлогч дарга 1, орлогч дарга 4 байхаар тогтоов.

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратын бүтцийг тогтоосон. /Хэрэг эрхлэх хэлтэс/

1992 оны 25-р тогтоолыг үндэслэн Нийслэл хотын 4 районыг 6 болгож, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааг Нийслэл хотын Засаг даргын тамгын газар болгон орон тоо зохион байгуулалтанд доорхи өөрчлөлтийг хийжээ. Үүнд

#### **Удирдлагын хэлтэс**

#### **Засаг захиргааны хэлтэс**

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Монгол улсын /шинэ/ Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн хорин наймдугаар зүйлийн 1, 3 дугаар заалтыг үндэслэн Нийслэлийн Удирдлагын Засаг даргаас гадна Засаг даргын орглогч 4,

Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга 1 байх, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дорь дурьдсан хэлтэс тасагтай байхаар тогтоов. Үүнд:

Засаг захиргааны хэлтэс

Нийслэлийн Засаг даргын дэргэд дор дурьдсан газар, хэлтэс алба байхаар тогтоосон  
Үүнд:

Хот байгуулалт, төлөвлөлтийн газар

1992 онд батлагдсан үндсэн хуулиар цоо шинэ бүтэцтэйгээр хуульчлагдсан билээ. Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн тавин есдүгээр зүйлд" Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж заасан билээ.

1994 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Монгол Улсын Их хуралаар "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тухай "Монгол улсын Засгийн газрын 1994.оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг тусд нь зохион байгуулан ажилуулах болсон нь засаг захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажлын ялгаа заагийг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Нийслэлийн засаг даргын /ажлын алба буюу/ Тамгын газар нь

Засаг захиргааны хэлтэс

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 тоот тогтоолоор Нийслэлийн Удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 1, Засаг даргын Тамгын газрын бүтцийг доорхи байдлаар тогтоосон. Үүнд: Төрийн Захирааны удирдлагын хэлтэс

Нийгмийн бодлогын хэлтэстэй байхаар тогтоосон.

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 11дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтол гарч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

## Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Төрийн захиргааны даргын үүргийг давхар хариуцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын бүтцийг нь:

## Төрийн Захиргаа хууль зүйн хэлтэс

2004 оны Засгийн газрын 182 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс / Олон нийттэй харилцах албатай/

## Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-нд 15 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /олон нийттэй харилцах болон хяналт-шинжилгээ үнэлгээний албатай/

## Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

## Нийгмийн хөгжлийн хэлтэс

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн "Нийслэлийн Засаг даргын 22 тоот захирамжаар Захирагчийн Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосон Захирагчийн ажлын алба нь :

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дүгээр сарын 24-нд 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч /Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч /Барилга , хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч / Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтыг нь

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс